



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ 2021 ОНЫ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/41/НА-СТА-ТӨА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу.



Улаанбаатар хот  
2022 он

Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор  
Ц.Наранчимэг  
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn  
Аудитын менежер: С.Нацагдорж  
Утас: 261885 Цахим хаяг: natsagdorjs@audit.gov.mn  
Аудитор: Д.Эрдэнэчимэг  
Утас: 261740 Цахим хаяг: erdenechimegda@audit.gov.mn  
Гэрээгээр гүйцэтгэсэн:  
Ингүүмэл жаргалант аудит ХХК-ийн  
Захирал Г.Энхтөр  
Цахим хаяг: ij17.audit@gmail.com

**Агуулга**

1. Аудитын санал дүгнэлт .....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан .....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан .....	6
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан .....	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	8
2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл .....	9
3. Аудитын тайлан .....	10
3.1 Ерөнхий зүйл .....	10
3.2 Дотоод хяналт .....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	11
3.4 Материаллаг байдал .....	11
4. Санхүүгийн тайлангийн тодруулга .....	11
4.1 Байгууллагын үйл ажиллагаа .....	11
4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин .....	12
4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого .....	13
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	15
5.1 Шилэн дансны мэдээлэл .....	15
6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	16
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	16
8. Аудитын илрүүлэлт .....	16
8.1 Залруулсан алдаа .....	16
8.2 Зөвлөмж .....	16
9. Аудитаар илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл .....	19

## Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АХГ	Аудитын хоёрдугаар газар
НА	Нотлох ажил
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨА	Төрийн өмчийн аж ахуйн нэгж
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТБОНӨАА	Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгж
ХХЗХ	Харилцаа холбооны зохицуулах хороо
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани

## 1. Аудитын санал дүгнэлт



### ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас: 26-04-37, Факс: 51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

2022.03.15 № 07/538  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ  
ХОРООНЫ ДАРГА Г.ЧИНЗОРИГ ТАНАА

#### Аудитын санал дүгнэлт

##### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Харилцаа холбооны зохицуулах хорооны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Харилцаа холбооны зохицуулах хорооны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

##### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

##### Асуудлыг онцолсон зүйл

Тайлант онд үндсэн үйл ажиллагааны орлогын гүйцэтгэл 15,784.6 сая төгрөг болж төлөвлөснөөс 6,053.7 сая төгрөг буюу 62.2 хувиар нэмэгдсэн нь үйлчлүүлэгчийн тоо өссөн, урьдчилж орсон орлогыг орлогоор хүлээн зөвшөөрсөн зэрэг нөлөөлсөн байна.

##### Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудалд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй зүйлсийг тодруулах ба тэдгээрийг аудитын хүрээнд нэгтгэсэн байдлаар авч үзсэн болно.

##### Бусад асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

\\10.10.10.20\Bichig\_Kherel\Yawsan\_Bichig\2022\0315 Audit\in 2 Газар - 18.Docx

001050773

Тайлант онд тус хороо нь Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.3-д заасны дагуу дотоод зохион байгуулалтын бүтцийг өөрчлөхгүйгээр 3 орон тоог хэмнэж ажилласан байна.

#### **Бусад мэдээлэл**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилтын хүрээнд 187 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 95.8 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

#### **Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

**2. Аудит хийсэн санхүүгийн тайлан****2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>ХӨРӨНГӨ</b>		
<b>1.1</b>	<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	22,666,245,300.43	27,088,240,868.05
1.1.2	Дансны авлага	2,531,240,062.06	2,367,373,927.91
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	73,070.33	1,584,033.03
1.1.4	Бусад авлага	235,329,400.21	200,817,174.14
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө		
1.1.6	Бараа материал	120,859,750.00	28,008,677.15
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	77,360,456.50	20,431,087.00
<b>1.1.11</b>	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>25,631,108,039.53</b>	<b>29,706,455,767.28</b>
<b>1.2</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
1.2.1	Үндсэн хөрөнгө	5,207,412,930.89	6,393,479,705.95
1.2.2	Биет бус хөрөнгө	1,768,316,933.83	2,157,196,831.03
<b>1.2.10</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>6,975,729,864.72</b>	<b>8,550,676,536.98</b>
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>32,606,837,904.25</b>	<b>38,257,132,304.26</b>
<b>2</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>		
<b>2.1</b>	<b>Өр төлбөр</b>		
<b>2.1.1</b>	<b>Богино хугацаат өр төлбөр</b>		
2.1.1.1	Дансны өглөг	52,764,920.15	9,021,496.72
2.1.1.2	Цалингийн өглөг	1,992,469.79	1,071,386.41
2.1.1.3	Татварын өр		2,862,128.80
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	2,739,159,864.29	82,709,182.20
<b>2.1.1.13</b>	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>2,793,917,254.23</b>	<b>95,664,194.13</b>
<b>2.1.2</b>	<b>Урт хугацаат өр төлбөр</b>		
2.1.2.1	Урт хугацаат зээл		
<b>2.1.2.6</b>	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	-	-
<b>2.2</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>2,793,917,254.23</b>	<b>95,664,194.13</b>
<b>2.3</b>	<b>Эздийн өмч</b>		
2.3.1	Өмч: - төрийн	1,169,840,273.85	1,169,840,273.85
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	265,550,416.39	1,204,335,204.46
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	1,409,477,000.00	1,409,477,000.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	26,968,052,959.78	34,377,815,631.82
2.3.9.1	Тайлангийн үеийн ашиг / алдагдал /	6,178,035,609.49	7,295,939,219.94
2.3.9.2	Өмнөх үеийн ашиг / алдагдал /	20,790,017,350.29	27,081,876,411.88
<b>2.3.11</b>	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>29,812,920,650.02</b>	<b>38,161,468,110.13</b>
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>32,606,837,904.25</b>	<b>38,257,132,304.26</b>

**2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан**

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	<b>Борлуулалтын орлого (цэвэр)</b>	<b>10,463,241,735.00</b>	<b>13,239,299,637.12</b>
2	Борлуулалтын өртөг		
3	<b>Нийт ашиг( алдагдал)</b>	<b>10,463,241,735.00</b>	<b>13,239,299,637.12</b>
4	Түрээсийн орлого		
5	Хүүний орлого	2,119,225,108.02	2,369,667,308.90
6	Ногдол ашгийн орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого	1,004,432,012.09	175,556,367.78
9	Борлуулалт, маркетингийн зардал	1,903,452,957.60	2,280,265,609.08
10	Ерөнхий ба удирдлагын зардал	3,896,100,606.43	4,634,490,952.79
11	Санхүүгийн зардал		
12	Бусад зардал	1,071,930,585.39	1,149,161,074.05
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	537,657.46	(2,545.02)
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(53,338,893.61)	
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17	Бусад ашиг ( алдагдал)	(484,577,860.05)	(424,663,912.92)
18	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг( алдагдал)</b>	<b>6,178,035,609.49</b>	<b>7,295,939,219.94</b>
19	Орлогын татварын зардал		
20	<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>6,178,035,609.49</b>	<b>7,295,939,219.94</b>
21	<b>Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)</b>		
22	<b>Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал)</b>	<b>6,178,035,609.49</b>	<b>7,295,939,219.94</b>
23	<b>Бусад дэлгэрэнгүй орлого</b>	-	-
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
	Бусад олз (гарз)		
24	<b>Орлогын нийт дүн</b>	<b>6,178,035,609.49</b>	<b>7,295,939,219.94</b>
25	<b>Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)</b>		

**2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан**

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	2021 оны 12-р сарын 31
1	<b>2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>1,169,840,273.85</b>	<b>265,550,416.39</b>	<b>1,409,477,000.00</b>	<b>20,790,017,350.29</b>	<b>23,634,885,040.53</b>
2	НБББ-ын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					-
3	<b>Залруулсан үлдэгдэл</b>	<b>1,169,840,273.85</b>	<b>265,550,416.39</b>	<b>1,409,477,000.00</b>	<b>20,790,017,350.29</b>	<b>23,634,885,040.53</b>
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				6,178,035,609.49	<b>6,178,035,609.49</b>
5	<b>2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>1,169,840,273.85</b>	<b>265,550,416.39</b>	<b>1,409,477,000.00</b>	<b>26,968,052,959.78</b>	<b>29,812,920,650.02</b>
6	НБББ-ын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				113,823,452.10	<b>113,823,452.10</b>
7	<b>Залруулсан үлдэгдэл</b>	<b>1,169,840,273.85</b>	<b>265,550,416.39</b>	<b>1,409,477,000.00</b>	<b>27,081,876,411.88</b>	<b>29,926,744,102.12</b>
8	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)		-		7,295,939,219.94	<b>7,295,939,219.94</b>
9	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		938,784,788.07			<b>938,784,788.07</b>
10	<b>2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>1,169,840,273.85</b>	<b>1,204,335,204.46</b>	<b>1,409,477,000.00</b>	<b>34,377,815,631.82</b>	<b>38,161,468,110.13</b>



**2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

	ҮЗҮҮЛЭЛТ	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>1.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>10,044,205,580.42</b>	<b>12,857,392,180.57</b>
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	9,949,087,983.08	10,341,522,146.59
	Бусад мөнгөн орлого	95,117,597.34	2,515,870,033.98
<b>1.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>5,902,681,167.32</b>	<b>6,868,599,041.06</b>
	Ажиллагчдад төлсөн	3,188,607,267.68	3,872,368,649.34
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	400,000,533.06	501,714,703.11
	Бараа материал худалдан авахад төлсөн	172,183,467.21	268,558,676.86
	Ашиглалтын зардалд төлсөн	79,525,510.30	45,453,075.60
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	119,440,920.08	113,318,562.47
	Бусад мөнгөн зарлага	1,942,923,468.99	2,067,185,373.68
<b>1.3</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>4,141,524,413.10</b>	<b>5,988,793,139.51</b>
<b>2</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>2.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>2,119,225,108.02</b>	<b>-</b>
	Хүлээн авсан хүүний орлого	2,119,225,108.02	
<b>2.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>1,105,816,979.08</b>	<b>1,566,795,026.87</b>
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	1,028,837,156.53	1,265,565,317.88
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	76,979,822.55	301,229,708.99
<b>2.3</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>1,013,408,128.94</b>	<b>(1,566,795,026.87)</b>
<b>3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>3.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>537,657.46</b>	<b>1,804.14</b>
	Валютын ханш	537,657.46	1,804.14
<b>3.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>-</b>	<b>4,349.16</b>
	Валютын ханш	-	4,349.16
<b>3.3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>537,657.46</b>	<b>(2,545.02)</b>
<b>4</b>	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>5,155,470,199.50</b>	<b>4,421,995,567.62</b>
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>17,510,775,100.93</b>	<b>22,666,245,300.43</b>
<b>6</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>22,666,245,300.43</b>	<b>27,088,240,868.05</b>

**2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл**

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

№	Үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт	2020 оны гүйцэтгэл	2021 оны			
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	<b>Борлуулалтын орлого (цэвэр)</b>	10,463,241.7	8,150,625.0	13,239,299.6	5,088,674.6	162.4
2	Борлуулалтын өртөг				-	
3	<b>Нийт ашиг( алдагдал)</b>	<b>10,463,241.7</b>	<b>8,150,625.0</b>	<b>13,239,299.6</b>	<b>5,088,674.6</b>	162.4
4	Хүүний орлого	2,119,225.1	1,500,000.0	2,369,667.3	869,667.3	157.9
5	Бусад орлого	1,004,432.0	80,313.0	175,556.4	95,243.4	218.5
6	Борлуулалт, маркетингийн зардал	<b>1,912,371.5</b>	<b>3,007,018.1</b>	<b>2,280,265.6</b>	<b>(726,752.5)</b>	75.8
7	Ерөнхий ба удирдлагын зардал	<b>3,887,182.1</b>	<b>5,049,938.0</b>	<b>4,634,491.0</b>	<b>(415,447.0)</b>	91.7
8	Бусад зардал	<b>1,071,930.6</b>	<b>50,982.8</b>	<b>1,149,161.1</b>	<b>1,098,178.3</b>	2,254.0
9	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	537.7	-	(2.5)	(2.5)	
10	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(53,338.9)	-	-	-	
11	Бусад ашиг (алдагдал) НА-ийн нөөц	(484,577.9)	-	(424,663.9)	(424,663.9)	
12	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>6,178,035.5</b>	<b>1,622,999.1</b>	<b>7,295,939.2</b>	<b>5,672,940.1</b>	449.5

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Харилцаа холбооны зохицуулах хорооны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд компанийн дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгадагч байгууллагад харьяа Нийгмийн даатгалын болон Татварын албатай өглөг авлагыг тооцоо нийлж баталгаажуулах, насжилт өндөртэй авлагыг барагдуулах, батлагдсан хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулах, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулж, мөрдөж ажиллахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 1 дүгээр сарын 22-ноос 2022 оны 3 дугаар сарын 15-ны хооронд Ингүүмэл жаргалант аудит ХХК-ийн Ахлах аудитор Э.Батчимэг, аудитор Ч.Минжүүр нар гүйцэтгэж, чанарын хяналтыг захирал Г.Энхтөр хэрэгжүүлсэн.

Харилцаа холбооны зохицуулах хорооны 2021 оны санхүүгийн тайланг Үндэсний аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн 01/139 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Дотоод хяналт

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцээгүй, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохироогүй байна. УСНББОУС-1 /Санхүүгийн тайлангийн толилуулга/-ын 4 дүгээр параграфт “Энэ стандарт нь Улсын үйлдвэрийн газраас бусад улсын секторын бүх байгууллагад мөрдөнө”, 5 дугаар параграфт “Улсын үйлдвэрийн газар нь бүх материаллаг талаараа НББОУС-д нийцсэн санхүүгийн тайланг толилуулах ёстой” гэж заасан бөгөөд 6 дугаар параграфт Улсын үйлдвэрийн газар гэдэг нь дараах бүх шинжийг агуулсан байгууллагыг хэлнэ.

- Байгууллага нь өөрийн нэрийн өмнөөс гэрээ хийх эрхтэй байх;
- Бизнесийг эрхлэн явуулах санхүүгийн болон үйл ажиллагааны эрх олгогдсон байх;
- Бизнесийн хэвийн нөхцөлд бараа болон үйлчилгээг ашигтайгаар эсвэл өртгөө бүрэн нөхөгдөх байдлаар өөр байгууллагад борлуулдаг байх;
- Тасралтгүй байх зарчмыг /холбоогүй талуудын бүтээгдэхүүнийг худалдан авахаас бусад тохиолдолд/ хангахын тулд Засгийн газраас байнгын санхүүжилт авах эрмэлзэлгүй байх;
- Улсын секторын байгууллагын хяналтад байх гэж тодорхойлсон байна.

Харилцаа холбооны зохицуулах хороо нь дээрх бүх шинжийг агуулж байгаа бөгөөд өөрийн орлогоор санхүүждэг, чиг үүргээ бие даан хараат бусаар хэрэгжүүлдэг байна. Иймд нягтлан бодох бүртгэлд УСНББОУС-ыг мөрдөх нь тохиромжгүй юм.

Харилцаа холбооны зохицуулах хорооны “Дотоод аудитын үйл ажиллагаа, хэрэгжүүлэх журам”-д байгууллагын дотоод аудитын үйл ажиллагаа нь эрсдэлд суурилсан байхаар заасан бөгөөд байгууллагын бүтээгдэхүүнүүдийн гүйцэтгэлийн байдлыг харгалзан дотоод аудитын ажлыг сонгож төлөвлөдөг байсан бол цаашид эрсдэлийн үнэлгээ хийх процесс, аргачлалыг тодорхой болгох зорилгоор байгууллагын “Үйл ажиллагааны эрсдэлийн

үнэлгээ хийх, баримтжуулах” баримт бичгийг боловсруулан 2022 оноос хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Харилцаа холбооны зохицуулах хорооны 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлого 13,586.9 сая төгрөгөөс 1 хувиар буюу 135.9 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

## **4. Санхүүгийн тайлангийн тодруулга**

### **4.1 Байгууллагын үйл ажиллагаа**

Харилцаа холбооны зохицуулах хорооны зорилго нь хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, харилцаа холбооны талаар төрөөс баримталж байгаа бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, радио давтамжийн зурвасыг хуваарилах, дугаарлалтын нэгдсэн төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх, үйлчлэгч, хэрэглэгчдийн эрх ашгийг тэнцвэртэй хамгаалах, бүх нийтийн үйлчилгээний үүргийн хэрэгжилтийг хангуулах, үйлчлэгчийн шударга өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

Хорооны дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйл, Цахим гарын үсгийн тухай хуулийн 34 дүгээр зүйл, Радио долгионы тухай хуулийн 51 дүгээр зүйл, Шуудангийн тухай хуулийн 9 дүгээр зүйл, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 30 дугаар зүйлд заасан бүрэн эрхээс гадна дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ гэж тодорхойлжээ. Үүнд:

- Харилцаа холбооны салбарын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох.
- Хорооны үйл ажиллагааны стратеги, зорилго, зорилтыг тодорхойлж, хэрэгжилтийг зохион байгуулах.
- Хорооны дүрмийн 5.2-т заасан төвийн дүрмийг батлах.
- Хуулиар олгосон бүрэн эрхийн хүрээнд холбогдох дүрэм, журам, заавар, аргачлалыг баталж мөрдүүлэх.
- Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, хуулийн этгээдээс тайлан, мэдээ, мэдээлэл, тодорхойлолт гаргуулан авах.
- Орон нутаг дахь харьяа салбар нэгжийн ажилтан болон төлөөлөгчийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох.
- Хууль тогтоомж болон хорооны дүрэмд заасан бусад чиг үүрэг.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд Төрийн байгууллага, албан газар, улсын төсөвт үйлдвэрийн газар гэсэн статустай байна. Өмчийн 100 хувийг төр, үүнээс Монгол улсын Засгийн газар 100 хувийг эзэмшиж байна.

#### 4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Харилцаа холбооны зохицуулах хороог Монгол улсын Засгийн газрын 2002 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 15 дугаар тогтоолыг үндэслэн байгуулсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд “Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй: ... 5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах;...” гэсэн заалттай нийцэж байна.

Харилцаа холбооны зохицуулах хороо нь дарга, орон тооны бус 6 гишүүнээс бүрддэг, хорооны дарга, гишүүдийг Ерөнхий сайд томилдог байна.

Харилцаа холбооны зохицуулах хороо нь Төлөөлөн удирдах зөвлөлгүй бөгөөд 6 гишүүнтэй байна. Хорооны 2019 оны 8 дугаар сарын 19-ний өдрийн 34 тоот тогтоолоор гишүүний урамшууллын нэг цагт олгох хэмжээг хорооны дарга, гишүүдэд 0.3 сая төгрөгөөр тогтоосон байна.

Монгол Улсын Засгийн газрын “2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.10-т “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно.” гэж заасан байна. Энэ хүрээнд жил бүр эд хөрөнгийн үзлэг тооллогын ажлын үр дүнг өмч хамгаалах зөвлөлийн хурлаар хэлэлцэж хөрөнгийн ашиглалт, хамгаалалтад хяналт тавих арга хэмжээ авсан байна.

Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1.3. “Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх;”-д заасны дагуу дотоод зохион байгуулалтын бүтцийг өөрчлөхгүйгээр 3 орон тоог хэмнэж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”;
- ЗГ-ын 2021 оны 124 тоот тогтоол “ТБОНӨБАҮ худалдан авах босго үнэ шинэчлэн тогтоох тухай”
- Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам./ХХЗХ-ны 2021 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн 24 тоот тогтоол/
- Телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлага./ХХЗХ-ны 2021 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн 02 тоот тогтоол/
- Радио, телевизийн газрын сүлжээний үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага./ХХЗХ-ны 2021 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн 23 тоот тогтоол/
- Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлага./ХХЗХ-ны 2021 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн 24 тоот тогтоол/

- Хүүхдийг зохисгүй агуулгаас хамгаалах радио, телевизийн хөтөлбөрийн дүрэм./ХХЗХ-ны 2021 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 62 тоот тогтоол/
- Харилцаа холбооны зах зээлд шударга өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх журам./ХХЗХ-ны 2021 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн 57 тоот тогтоол/

#### 4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Харилцаа холбооны зохицуулах хорооны тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	22,666,245.30	27,088,240.9	4,421,995.6
Авлага	2,766,642.5	2,569,775.1	(196,867.4)
Бараа материал	120,859.8	28,008.7	(92,851.1)
Урьдчилж төлсөн зардал/ тооцоо	77,360.5	20,431.1	(56,929.4)
Үндсэн хөрөнгө	5,207,412.9	6,393,479.7	1,186,066.8
Биет бус хөрөнгө	1,768,316.9	2,157,196.8	388,879.9
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>32,606,837.9</b>	<b>38,257,132.3</b>	<b>5,650,294.4</b>
Богино хугацаат өглөг	2,793,917.3	95,664.2	(2,698,253.1)
Эздийн өмч	29,812,920.6	38,161,468.1	8,348,547.5
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>32,606,837.9</b>	<b>38,257,132.3</b>	<b>5,650,294.4</b>

Банкин дахь мөнгөний үлдэгдэлд харилцах дансанд байгаа 6,542.0 сая төгрөг, хугацаатай хадгаламж 20,546.2 сая төгрөг байна.

Шалгагдагч байгууллагын мөнгөн хөрөнгөнөөс дампуурсан банк, төлбөрийн чадваргүй болсон Чингис хаан, Үндэсний хөрөнгө оруулалтын банканд байршуулсан хөрөнгө байхгүй байна.

Авлагын үлдэгдэлд төлбөртэй үйлчилгээний авлага 4,515.1 сая төгрөг, найдваргүй авлагын хасагдуулга 2,155.5 сая төгрөг, ажилчидтай холбоотой авлага 7.7 сая төгрөг, тэмдэгтийн хураамжийн авлага 1.6 сая төгрөг, бусад авлага 200.8 сая төгрөгийг эзэлж байна.

Авлагын үлдэгдэлд хугацаандаа байгаа 4,717.5 сая төгрөгийн, хугацаа хэтэрсэн 7.7 сая төгрөгийн найдваргүй авлага байна. Найдваргүй авлагыг авлагын насжилтын аргаар тооцдог байна. Тайлант онд 424.7 сая төгрөгийн найдваргүй авлагын нөөц байгуулж, хорооны шийдвэрээр 108.3 сая төгрөгийн найдваргүй авлагыг данснаас хассан байна.

Тайлант онд автомашины 4 грашийн түрээсийн төлбөрт 20.4 сая төгрөгийн урьдчилгаа шилжүүлсэн байна. Урьдчилгаа дансны эхний үлдэгдэлд бүртгэлтэй 63.5 сая төгрөгийн ажлын гүйцэтгэлийг тайлант онд дүгнэн, акт үйлдэж үндсэн хөрөнгийн дансанд шилжүүлэн бүртгэсэн байна.

2019 онд гүйцэтгэсэн зөвлөх үйлчилгээний ажлын гүйцэтгэлийг Үндэсний аудитын газрын өгсөн зөвлөмжийн дагуу бараа материалд бүртгэсэн байсан бөгөөд ашиглах хугацаа дууссан тул 2021 онд зардалд тооцсоноос шалтгаалж бараа материалын үлдэгдэл 28.0 сая төгрөг болж 92.9 сая төгрөгөөр буурсан байна.

Тайлант онд үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгө байхгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэлд ашиглалтгүй бараа материалын үлдэгдэл байхгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн нь дараах шалтгаантай байна. Үүнд:

Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээ хийлгэснээр 938.8 сая төгрөгөөр, шинээр 1,307.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан, их засварын зардал 72.9 сая төгрөгийн хөрөнгөөр тус тус нэмэгдэж, ТӨБЗГ-ын шийдвэрээр 583.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж, тайлант онд 1,120.3 сая төгрөгийн элэгдлийн зардал тооцсон байна.

Үндсэн хөрөнгөөс ТӨБЗГ-ын 2021 оны А-1/1521 дугаар шийдвэрээр нийт 92.6 сая төгрөгийн өртөгтэй, 92.6 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй 23 ширхэг хөрөнгө, 2021 оны А-1/1803 шийдвэрээр 32.7 сая төгрөгийн өртөгтэй, 32.7 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй 69 ширхэг хөрөнгө, 2021 оны 518 дугаар шийдвэрээр 458.0 сая төгрөгийн өртөгтэй, 458.0 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй 94 ширхэг хөрөнгийг акталсан байна.

Биет бус хөрөнгө 388.9 сая төгрөгөөр өссөн нь шинээр хөрөнгө худалдан авснаас шалтгаалжээ.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэлд цалингийн өглөг 1.1 сая, ХХОАТ-ын өглөг 2.9 сая, байгууллагад өгөх өглөг 9.0 сая, урьдчилж орсон орлого 82.7 сая төгрөгийн өр төлбөрүүд байна.

Шалгагдагч байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт үйл ажиллагааны зардлын хүлээн зөвшөөрөлт ба үнэлгээг мөнгөөр төлөгдсөн эсэхээс үл хамааран зардал гэж хүлээн зөвшөөрч тусгахаар заасан байна.

Санхүүгийн тайланд зардал өртгийн талаарх мэдээллийг бэлтгэх зорилгын дагуу борлуулалт маркетингийн зардал, ерөнхий удирдлагын зардал, бусад зардал гэж ангилсан байна.

#### 4.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Харилцаа холбооны зохицуулах хорооны дүрмийн 5.6.9 “Хорооны төсөв болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний төслийг боловсруулах, төсвийг бүрдүүлж, зарцуулалтад хяналт тавих” гэж заасны дагуу эрх зүй, мэдээлэл, захиргааны асуудал хариуцсан нэгж болох Захиргаа удирдлага, хамтын ажиллагааны газар хорооны үйл ажиллагааны орлого, зардал, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө боловсруулж, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйл “Зохицуулах хорооны бүрэн эрх”, 9.1.16 “Зохицуулах хорооны төсөв, ажлын албаны жилийн төлөвлөгөөг батлах” гэж заасны дагуу Харилцаа холбооны зохицуулах хороогоор батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Харилцаа холбооны зохицуулах хорооны 2020 оны 83 дугаар тушаалаар 2021 оны орлого, зардал, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 9,730.9 сая төгрөгөөр, нийт зардлыг 10,180.0 сая төгрөг байхаар тогтоосон байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 2,078.1 сая төгрөгийг төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр 15,784.5 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 8,488.6 сая төгрөгийн зардал гарган, 7,295.9 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

Хүснэгт 2. 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин /мянган төгрөгөөр/

д/д	Үзүүлэлт	2020 оны гүйцэтгэл	2021 оны		Зөрүү	Хувь
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
	<b>Үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт</b>					
1	Үндсэн үйл ажиллагааны орлого	10,463,241.7	8,150,625.0	13,239,299.6	5,088,674.6	162.4
2	Хүүний орлого	2,315,357.2	1,500,000.0	2,369,667.3	869,667.3	157.9
3	Бусад орлого	808,300.0	80,313.0	175,556.4	95,243.4	218.6
	<b>Нийт орлого</b>	<b>13,586,898.9</b>	<b>9,730,938.0</b>	<b>15,784,523.3</b>	<b>6,053,585.3</b>	<b>162.4</b>
4	Үүнээс: Цэвэр борлуулалт	13,586,898.9	9,730,938.0	15,784,523.3	6,053,585.3	162.4

	<b>Нийт зардал</b>	<b>7,408,863.3</b>	<b>8,107,938.9</b>	<b>8,488,584.1</b>	<b>380,645.2</b>	<b>104.7</b>
	Үүнээс:					
5	а) Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	-	-	-	-	-
6	б) Борлуулалт, маркетингийн зардал	1,903,452.9	3,007,018.1	2,280,265.6	(726,752.5)	75.8
7	в) Ерөнхий ба удирдлагын зардал	3,896,100.6	5,049,938.0	4,634,491.0	(415,447.0)	91.8
8	г) Бусад зардал	1,609,309.8	50,982.8	1,573,827.5	1,522,844.7	2986.9
9	<b>Цэвэр ашиг, алдагдал</b>	<b>6,178,035.6</b>	<b>1,622,999.1</b>	<b>7,295,939.2</b>	<b>5,672,940.1</b>	<b>349.5</b>

Нийт орлогын гүйцэтгэл 15,784.5 сая төгрөг болж төлөвлөснөөс 6,053.6 сая төгрөг буюу 62.2 хувиар давсан нь үйлчлүүлэгчийн тоо өссөн, урьдчилж орсон орлогын гүйцэтгэл голлон нөлөөлсөн байна.

Нийт зардлын гүйцэтгэл 8,488.6 сая төгрөг болж, төлөвлөснөөс 380.6 сая төгрөг буюу 4.6 хувиар илүү гүйцэтгэлтэй байна. Энэ нь үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал гол нөлөө үзүүлсэн байна.

Их засвар, хөрөнгө оруулалтын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу 13 нэр төрлийн бараа, ажил үйлчилгээний ажилд өөрийн эх үүсвэрээс 1,586.8 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн байна.

## 5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

### 5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 11 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Харилцаа холбооны зохицуулах хороо нь тайлант онд 20,986.1 сая төгрөгийн 415 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 123.5 сая төгрөгийн 4 мэдээллийг ил тод байршуулаагүй зөрчилтэй байна.

Энэ нь шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.1 "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2 заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ" гэж заасантай тус тус нийцэхгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Шилэн дансны тухай хуулийн зөрчилд зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй, байна гэж дүгнэлээ.



## 6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар 2021 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланг хамруулж, нийт 243.3 сая төгрөгийн 11 алдаа зөрчил илрүүлсэн бөгөөд жилийн эцэст илрүүлсэн зөрчлөөс 132.8 сая төгрөгийн алдаа, зөрчлийг залруулж арилгасан ба бусад алдаа, зөрчлийг аудитын илрүүлэлтэд нэмж тусгасан болно.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 2,326.2 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 31.3 сая төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өгснөөс албан шаардлага, зөвлөмж 100 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 3. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	2,326,222.3	1	2,326,222.3	-	-	100.0
Зөвлөмж	3	31,308.4	3	31,308.4	-	-	100.0
Нийт дүн	4	2,357,530.7	4	2,357,530.7	-	-	100.0

## 7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар тусгай зөвшөөрлийн төлбөрийн авлага, найдваргүй авлагын хасагдуулгыг хэрхэн тооцох талаар нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт хэрхэн тусгасан байдалд анхаарал хандуулна.

## 8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 134.2 сая төгрөгийн 7 алдаа зөрчил илэрснээс, 120.5 сая төгрөгийн 2 алдааг залруулж, 13.7 сая төгрөгийн алдаа зөрчилд 5 зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй алдаа, зөрчлийн дүн 13.7 сая төгрөг нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшин 135.9 сая төгрөгөөс хэтрээгүй тул Зөрчилгүй дүгнэлт өглөө.

### 8.1 Залруулсан алдаа

Санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 120.5 сая төгрөгийн 2 алдааг залрууллаа. Үүнд:

- Биет болон биет бус хөрөнгийн элэгдэл, хорогдлын тооцооллыг давтан шалгахад элэгдлийн зардлыг 111.5 сая төгрөгөөр илүү, 1.2 сая төгрөгөөр дутуу тооцоолсныг.
- Оффисын зориулалттай 570,000.0 мянган төгрөгийн үнэ бүхий үл хөдлөх хөрөнгө худалдан авсан бөгөөд худалдах худалдан авах гэрээнд ҮХЭХ борлуулсны орлогын албан татварыг худалдагч тал хариуцна гэж заасны дагуу холбогдох татварыг суутгаагүй байна. Гэвч 2021 оны 4 дүгээр улиралд Суутган төлөгчийн хувь хүнд олгосон орлогод ногдуулан суутгасан албан татварын тайлан /ТТ-12/-аар 10,200.0 мянган төгрөгийн татварыг төлөхөөр тайлагнаж татварын өр үүсгэснийг.

### 8.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

## **1. Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөтэй холбоотой асуудал**

### **Илрүүлэлт:**

Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнөөс программ хангамжийн ашиглалтыг сайжруулах, өгөгдлийн баазад радио давтамжийн хуваарилалт, олголтын мэдээллийг оруулах, нэгдсэн санг шинэчлэх лиценз худалдан авах зардлыг 3.0 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан. Мөн их засварын зардлыг хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд нэгтгэн баталсан байна.

Энэ нь Засгийн газрын 2016 оны 268 тоот тогтоолоор баталсан "Харилцаа холбооны зохицуулах хорооны дүрэм"-ийн 3.1.10 "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалтыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### **Өгсөн зөвлөмж:**

Орлого, зардал, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг боловсруулахдаа тооцоо судалгааг үндэслэн орлого зардлыг зүйл тус бүрээр, хөрөнгө оруулалтыг нэр төрөл тус бүрээр, их засвар, барилгын ажлын төлөвлөгөөг тусад нь төлөвлөх, батлагдсан хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулах.

## **2. Авлагатай холбоотой асуудал**

### **Илрүүлэлт:**

Насжилт өндөртэй шийдвэрлэгдээгүй 7.7 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалтын дагуу өглөг авлагыг баталгаажуулж ажиллах" гэсэн заалтыг зөрчсөн, оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

### **Өгсөн зөвлөмж:**

Авлагыг насжилтаар нь ангилан, авлагын нөхцөл шалтгааныг тодруулан барагдуулах ажлыг зохион байгуулах

## **3. Авлагатай холбоотой асуудал**

### **Илрүүлэлт:**

Суутгагчийн хувь хүнд олгосон орлогоос суутгасан албан татварын авлага 1.7 сая төгрөгийг санхүүгийн тайланд дутуу тусгасан байна.

Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.10 "Татвар төлөгч нь хууль тогтоомж болон татварын албанаас баталсан заавар, аргачлал, маягт, дүрэм, журмыг дагаж мөрдөх үүрэгтэй" гэж заасныг зөрчсөн, оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

### **Өгсөн зөвлөмж:**

Суутгагчийн хувь хүнд олгосон орлогоос суутгасан албан татварын тайланг санхүүгийн тайлан, нягтлан бодох бүртгэлийн журнал, ажил гүйлгээг үндэслэн тайлагнах.

## **4. Өглөгтэй холбоотой асуудал**

### **Илрүүлэлт:**

Жилийн эцсийн санхүүгийн тайланд тусгагдсан татвар, НДШ-ийн өглөг, авлагын үлдэгдлийг ТТ-11, НД-8 тайлангуудтай тулган шалгахад ХХОАТ-ын өглөгийг 1.3 сая төгрөгөөр, НДШ-ийн авлагыг 0.01 сая төгрөгийн зөрүүтэй тайлагнасан байна.

Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.10 "Татвар төлөгч нь хууль тогтоомж болон татварын албанаас баталсан заавар, аргачлал, маягт, дүрэм, журмыг дагаж мөрдөх үүрэгтэй" гэж заасныг зөрчсөн, оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Татвар, НДШ-ийн ногдуулалт хийхдээ холбогдох хуульд заасан нийтлэг журмыг баримтлах. Тайлант хугацааны эцэст харьяалах Татвар, НД-ын байгууллагатай өглөг авлагын тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулж ажиллах.

**5. НБББББ-тэй холбоотой асуудал**

Илрүүлэлт:

Тус байгууллагын батлагдсан НБББББ-т УСНББОУС-ыг мөрдөхөөр заасан байгаа нь хорооны нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд нийцэхгүй байна.

Энэ нь нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.4 “Энэ хуулийн 4.1.3-т заасан стандартыг Төсвийн тухай хуулийн 4.1.34-т заасан байгууллага мөрдөнө” гэсэн заалт, УСНББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулгын 5 дугаар параграфын заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

НБББББ-ийг байгууллагын үйл ажиллагааны чиглэл, бие даасан хараат бус байдал, холбогдох хууль, олон улсын стандарт, дүрэм, журамд нийцүүлэн шинэчлэн боловсруулж, баталж, мөрдөх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Залруулга		Акт		Үүнээс Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж		
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
					Санхүүгийн тайлангийн асуудлаар												
1	Харилцаа холбооны зохицуулах хороо	АХГ-2022/41/НА-СТА-ТӨА	ХО-н батлагдсан төлөвлөгөөг хэтрүүлэн зарцуулсан	Төлөвлөгөөг боловсруулахдаа тооцоо судалгааг үндэслэн орлого зардлыг зүйл тус бүрээр, хөрөнгө оруулалтыг нэр төрөл тус бүрээр, их засвар, барилгын ажлын төлөвлөгөөг тусад нь төлөвлөх, батлагдсан хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулах.	1	2,998.7									1	2,998.7	
2	Харилцаа холбооны зохицуулах хороо	АХГ-2022/41/НА-СТА-ТӨА	Насжилт өндөртэй шийдвэрлэгдээгүй 7,735.1 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна	Авлагын нөхцөл шалтгааныг тодруулан барагдуулах ажлыг зохион байгуулах	1	7,735.1									1	7,735.1	
3	Харилцаа холбооны зохицуулах хороо	АХГ-2022/41/НА-СТА-ТӨА	Суутгагчийн хувь хүнд олгосон орлогоос суутгасан албан татварын авлага 1,644.8 мянган төгрөгийг санхүүгийн тайланд дутуу тусгасан байна.	Холбогдох татварын тайланг санхүү, аж ахуйн үйл ажиллагааны тайлан тэнцэлд үндэслэн үйлдэх.	1	1,644.8									1	1,644.8	
4	Харилцаа холбооны зохицуулах хороо	АХГ-2022/41/НА-СТА-ТӨА	Жилийн эцсийн санхүүгийн тайланд тусгагдсан татвар, НДШ-ийн өглөг, авлагын үлдэгдлийг ТТ-11, НД-8 тайлангуудтай тулган шалгахад ХХОАТ-ын өглөгийг 1,316.6 мянган төгрөгөөр, НДШ-ийн авлагыг 12.6 мянган төгрөгийн зөрүүтэй тайлагнасан байна.	Татвар, НДШ-ийн ногдуулалт хийхдээ холбогдох хуульд заасан нийтлэг журмыг баримтлах. Тайлант хугацааны эцэст харьяалах Татвар, НД-н байгууллагатай өглөг авлагын тооцоо нийлж ажиллах.	1	1,329.2									1	1,329.2	

Харилцаа холбооны зохицуулах хорооны 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

5	Харилцаа холбооны зохицуулах хороо	АХГ-2022/41/НА-СТА-ТӨА	Батлагдсан НБББББ-т УСНББОУС-ыг мөрдөхөөр заасан байгаа нь тус хорооны нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд нийцэхгүй байна.	НБББББ-ийг байгууллагын үйл ажиллагааны онцлог, холбогдох хууль, олон улсын стандарт, дүрэм, журамд нийцүүлэн шинэчлэн боловсруулж, баталж, мөрдөж ажиллах	1	-									1	-	
6	Харилцаа холбооны зохицуулах хороо	АХГ-2022/41/НА-СТА-ТӨА	Биет болон биет бус хөрөнгийн элэгдэл, хорогдлын тооцооллыг давтан шалгахад элэгдлийн зардлыг 1,278.7 мянган төгрөгөөр дутуу, 111,543.5 мянган төгрөгөөр илүү тооцоолсон байна.	Аудитын явцад залруулсан	1	110,264.7	1	110,264.7									
7	Харилцаа холбооны зохицуулах хороо	АХГ-2022/41/НА-СТА-ТӨА	2021 оны 4-р улиралд Суутган төлөгчийн хувь хүнд олгосон орлогод ногдуулан суутгасан албан татварын тайлан /ТТ-12/-аар 10,200.0 мянган төгрөгийн татварыг төлөхөөр тайлагнаж татварын өр үүсгэсэн байна.	Аудитын явцад залруулсан	1	10,200.0	1	10,200.0									
<b>ДҮН</b>					7	134,172.5	2	120,464.7							5	13,707.8	
Санхүүгийн тайлангийн асуудлаар шалгасан нийцлийн асуудал																	
1	Харилцаа холбооны зохицуулах хороо	АХГ-2022/41/НА-СТА-ТӨА	Харилцаа холбооны зохицуулах хороо нь тайлант онд 20,896,140.5 мянган төгрөгийн 415 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 123,549.8 мянган төгрөгийн 4 мэдээллийг ил тод байршуулаагүй зөрчилтэй байна.	Шилэн дансны тухай хуулийн зөрчилд албан шаардлага хүргүүлэх	1	123,549.8								1	123,549.8		
<b>ДҮН</b>					1	123,549.8								1	123,549.8		
<b>НИЙТ ДҮН</b>					8	257,722.3	2	120,464.7						1	123,549.8	5	13,707.8



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 357/20150458  
АХГ- 2022/41)чА- СТА- ТӨА

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу Харилцаа холбооны зохицуулах хорооны 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны цахим системд 415 мэдээлэл байршуулахаас, 411 мэдээллийг хугацаандаа оруулж, 123,549,753.00 төгрөгийн дүн бүхий 4 мэдээллийг байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6.4 "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.4.4 "таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ гэсэн заалтыг мөрдөх" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, мэдээллийг ил тод, хугацаанд нь байршуулж байх, зөрчлийг арилгаж, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Харилцаа холбооны зохицуулах хорооны дарга Г.Чинзориг, санхүүгийн хэлтсийн дарга Н.Халиунаа нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ИНГҮҮМЭЛ ЖАРГАЛАНТ АУДИТ ХХК-ИЙН  
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ  
С.НАЦАГДОРЖ  
Г.ЭНХТӨР



Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага-тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,  
Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig\_Kherig\Alban Shaardlaga\2022\0315 Auditin 2 Газар-13.Docx

00108C0981







